



ЕРӨӨ СУМЫН АРДЧИЛСАН  
НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2020.04.30 № 00А-2020/04-НА-23  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Ерөө сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Ерөө сумын Ардчилсан намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020612

## Дүгнэлт

Ерөө сумын Ардчилсан намын хорооны Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Ерөө сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр / 4 хуудас /-ийг хавсаргав.

Хувийг: Ерөө сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН 2020 ОНЫ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**УРИА: ЭХ НУТАГТАА ЭЗЭН НЬ БАЙЦГААЯ.**

Ерөө сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөрийн зорилт нь эдийн засаг, нийгэм, засаглалын гурван тулгуурт бодлогыг хэрэгжүүлэн, төрөлжсөн эдийн засагтай, чанар хүртээмжтэй нийгмийн суурь үйлчилгээг үзүүлсэн, шударга засаглал бүхий бүтээлч иргэдтэй жишиг сум болгоход оршино.

**Нэг. ЭДИЙН ЗАСАГ**

- Аж үйлдвэр, дэд бүтэц
- Хөдөө аж ахуй
- Аялал жуулчлал

**1.1 Аж үйлдвэр, дэд бүтэц**

1.1.1 Орон нутгийн түүхий эдийн нөөцийг ашиглан барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого баримтална.

1.1.2 Төмрийн хүдэр олборлох үйлдвэрлэлд тулгуурлан ашигт малтмалыг боловсруулах үйлдвэрийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулах нөхцөлийг судалж, дэмжлэг үзүүлнэ.

1.1.3 “Сүү хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, сүүний хөргөлтийн нөөц сав байгуулах санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулж, шийдвэрлэнэ.

1.1.4 Бугант тосгоныг түшиглэн мод, модон материалаар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

1.1.5 Мал аж ахуй, газар тариалангийн түүхий эдийг боловсруулах үйлдвэр, цехүүдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

1.1.6 Худалдаа аж ахуйн үйлчилгээний төвлөрсөн цэг, салбарын тоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ стандартын шаардлага хангасан хүнсний захыг барьж, ашиглалтад оруулах санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулж, шийдвэрлүүлнэ.

1.1.7 Төмс, хүнсний ногоог жижиглэнгээр савлах цех байгуулах, хот суурин газрын сүлжээ дэлгүүрүүдэд гэрээгээр ханган нийлүүлэх, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангана.


1.1.8 Эцсийн бүтээгдэхүүн бий болгох жижиг, дунд үйлдвэрийг үе шаттайгаар дэмжиж, орон нутгийн болон бүсийн хэрэгцээг хангахыг бодлогоор дэмжинэ.

1.1.9 Ерөө сумын болон Бугант тосгоны төвийн доторх замыг засаж сайжруулах, хатуу хучилттай замын хэмжээг нэмэгдүүлэх санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулах санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

1.1.10 “Гудамж төсөл”-ийг сум, тосгоны хэмжээнд хэрэгжүүлж, нийтийн эзэмшлийн зам, талбайг камержуулж, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн иргэдийн ая тухтай орчныг бүрдүүлнэ.

1.1.11 Бугант тосгоны хорооллын хэсгийн үерийн даланг засварлаж, шаардлагатай хэсгүүдэд шинээр гүүр барина.

1.1.12 Ерөө сумын Хандгайтын хэсгийн хатуу хучилттай замаас Бугант тосгон хүртэлх замыг хатуу хучилттай болгох санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулах санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.



1.1.13 Бугант тосгонд стандартын шаардлагад нийцсэн халуун усны газрыг барьж ашиглалтад оруулна.

1.1.14 Бугант тосгоны төвийн хэсэг болон өлөнтийн хэсэгт эрүүл ахуйн шаардлага хангасан гүний худаг гаргаж, ашиглалтад оруулна.

1.1.15 Сумын төвд инженерийн шугам сүлжээг шинээр барих санхүүжилтийг холбогдох шатны төсөвт тусгуулж, хамтран хэрэгжүүлнэ.

1.1.16 Бугант тосгоны инженерийн шугам сүлжээг шинэчлэн засварлаж, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.

1.1.17 Шинэ суурьшлын бүсэд эдэлбэр газартай орон сууцны хотхоныг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран байгуулна.

1.1.18 Сум, тосгоны хог хаягдлын менежментийг сайжруулж, төвлөрсөн хогийн цэгийг стандартад нийцүүлэн хашаажуулж, хамгаалалттай болгоно.

1.1.19 Бугант тосгоны төвийн болон гэр хорооллын замыг сайжруулж, гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.

1.1.20 Сум, тосгоны хурдан морины уралдааны замыг шинээр тогтоон, нөхцөлийг сайжруулж, унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

1.1.21 Бугант тосгоны малчдын өвөлжилтийн бэлтгэл хангуулах зорилгоор Ерөө голын Ахь, Угтаалын хэсэгт гүүр барих санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулж, шийдвэрлүүлнэ.

1.1.22 Сум, тосгоны цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийн шугам сүлжээний ашиглалтыг сайжруулж, хүчдэлийн уналтыг багасгах, тарифын хөнгөлөлттэй электрон тоолуураар хангах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

1.1.23 Ерөө сумын төвд 150 хүүхдийн хүчин чадалтай дотуур байрыг барьж ашиглалтад оруулах санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулж, шийдвэрлүүлнэ.

1.1.24 “Жорлонгоо өөрчилье” төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.1.25 Бугант тосгоны орон сууцны орцны засварыг хийж, иргэдийн амьдрах таатай орчныг бий болгоно.

1.1.26 Ерөө суманд соёлын төвийн барилгыг шинээр барих санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулах санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

## **2. ХӨДӨӨ АЖ АХУЙ**

### **2.1 “ШИНЭ ХӨДӨӨ” хөтөлбөр**

2.1.1 Газар тариалангийн үйлдвэрлэлд техникийн шинэчлэл хийж, баталгаат сортын үрийн хангамж, ургамал хөрс хамгаалалт, услалтын систем барих зэрэг агро техникийн цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.2 Төмс, хүнсний ногоо тариалагчдыг хүлэмжээр хангах, борлуулалтыг нэмэгдүүлэхийг бодлогоор дэмжинэ.

2.1.3 Сумын төвийг дахин төлөвлөж, ногоон байгууламж, дэд бүтэц, барилга байгууламж бүхий орчин үеийн сууринг хөгжүүлнэ.

2.1.4 “Шинэ сум” төслийг иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.

### **2.2 Бэлчээр ашиглалт**

2.2.1 Сумын бэлчээр ашиглалтыг сайжруулах журам, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.



2.2.2 Малчдыг бүлэг, хэсгийн зохион байгуулалтад оруулж, бэлчээрийг гэрээгээр ашиглуулах хэлбэрээр бэлчээрт малын даацыг тохируулан, бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурилсан менежментийг нэвтрүүлнэ.

2.2.3 Сумын хэмжээнд ашиглагдаагүй, ашиглалт багатай бэлчээрийн нөөцийг тогтоож дэд бүтэц, усан хангамжийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

2.2.4 Ашиглалт багатай, олон жил ашигласнаас хөрсний үржил шим муудсан болон олон жилийн судалгаагаар ургац муу өгдөг тариалангийн талбай болон бусад нөөц газраас олон наст уургийн агууламж өндөртэй тэжээлийн ургамал тариалах зориулалтаар малчдын бүлэг, хоршоодод эзэмшүүлэх бодлого баримтална.

2.2.5 Малыг тооноос чанарт шилжүүлэх, бэлчээрийн даацыг тохируулан хамгаалж, сайжруулсан малчин өрх, бүлэг, хэсгийг бодлогоор дэмжинэ.

2.2.6 Сэргээгдэх эрчим хүчийг ашиглан гадаргын ус багатай газруудад нийтийн эзэмшлийн худаг шинээр гаргаж, бэлчээр ашиглах боломжийг нэмэгдүүлнэ.

2.2.7 Малчдын бэлчээрт ойрхон тариалангийн талбайг тусгаарлах хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, тариалангийн талбайг хашлага, хаалттай болгоход бодлогоор дэмжинэ.

2.2.8 Бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх зорилгоор алсын зам, давааг засаж сайжруулна.

### **2.3 Газар тариалан**

2.3.1 Газар тариалангийн үрийн аж ахуйн системийг боловсронгуй болгож, сэргээн хөгжүүлэх, хөрс, цаг уурын онцлогт тохирсон, баталгаат сортын үрийн хангамжийг нэмэгдүүлнэ.

2.3.2 Усалгаатай газар тариаланд гадаргуугийн усалгаа, бага оврын услалтын системийг нэвтрүүлнэ.

2.3.3 Малын тэжээлийн үйлдвэр байгуулах санаачилга гаргасан иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.

2.3.4 Газрын үржил шимийг зохистой ашиглаж, газар тариалангийн үйлдвэрлэлд орчин үеийн технологи, инновац нэвтрүүлэхийг дэмжинэ.

2.3.5 Ургамал хамгаалалтын орчин үеийн арга технологийг иж бүрэн хэрэгжүүлж, тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, хортон шавжаас хамгаалах, үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлнэ.


2.3.6 Усалгаатай газар тариаланг хөрс, усны нөөцийн судалгаанд үндэслэн хөгжүүлэх бодлого баримтална.

2.3.7 Үрийн чанарыг сайжруулах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтарч, үр үржүүлгийн аж ахуйг бодлогоор дэмжинэ.

2.3.8 Төмс, хүнсний ногоо тариалагч иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагаа, борлуулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.3.9 Сэлэнгэ аймгийн уул уурхайн бодлогын хүрээнд томоохон компаниудын хүнсний болон ахуйн хэрэгцээний бараа бүтээгдэхүүнийг орон нутгийн аж ахуйн нэгж, үйлдвэр эрхлэгчдээс хангах ажлыг зохион байгуулна.

2.3.10 Сум, тосгонд техник дундын үйлчилгээний төв байгуулах арга хэмжээ авч, өрхийн тариалан эрхэлдэг иргэдийг дэмжинэ.



## 2.4 Мал аж ахуй

2.4.1 Малыг тооноос илүү чанарт шилжүүлэх, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан мал аж ахуйг бодлогоор дэмжинэ.

2.4.2 Сумын хэмжээнд малын үүлдэр омог, угшлыг баталгаажуулах, төрөлжсөн хэлбэрээр өсгөж үржүүлнэ.

2.4.3 Мал аж ахуйн эрүүл бүсийг баталгаажуулж, мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

2.4.4 Махыг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулах, малыг вакцин, туулгад бүрэн хамруулж, эрүүлжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

2.4.5 Малаас гарч буй түүхий эд болон арьс шир, дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэгчдийг дэмжинэ.

2.4.6 Малын үүлдэр угсааг сайжруулах, өндөр ашиг шимтэй болон нутгийн шилмэл үүлдрийн малын эзлэх хувийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

2.4.7 Хадлан, дарш бэлтгэх, тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжиж, малчдыг хадлангийн техник хэрэгслээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.4.8 Гахай, шувуу, зөгий, загас болон бусад туслах аж ахуйг өрх, фермерийн аж ахуйг дэмжинэ.

## 3. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

3.1 Байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэн аялал жуулчлалын хөтөлбөр боловсруулж, Ерөө бүсийг дагасан бизнес, ажил үйлчилгээг хөгжүүлэх бодлого баримтална.

3.2 Уул уурхайн ашиглалтын явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг нэмэгдүүлнэ.

3.3 Ерөөгийн халуун рашааныг түшиглэн стандартад нийцсэн амралт, сувиллын цогцолборыг бий болгоно.

3.4 Сум, тосгоны байгалийн нөөцөд тулгуурлан загас үржүүлэг, усан замын аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй хамтран ажиллана.

## 4. НИЙГЭМ

- Эрүүл мэнд
- Боловсрол
- Хөдөлмөр эрхлэлт

### 4.1. Эрүүл мэнд

4.1.1 Иргэдийн бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор сумын спорт цогцолбор, ахмадын сувиллын тоног төхөөрөмжийг сайжруулж, тогтмол ажиллагаатай болгоно.

4.1.2 Бугант тосгонд ахмадын сувилал байгуулах санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулж, шийдвэрлүүлнэ.

4.1.3 Жил бүр сум, тосгоны иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.1.4 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах аяныг өрнүүлж, халдварт, халдварт бус өвчлөлийг бууруулах, тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.

4.1.5 Олон нийтийн оролцоонд тулгуурлан “Архидалттай тэмцэх” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.



4.1.6 Сум, тосгоны ЭМТ-ийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэх санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулж, шийдвэрлүүлнэ.

4.1.7 Эмийн чанар хүртээмжийг дээшлүүлж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.1.8 Сум, тосгоны ЭМТ-ийн эмч, эмнэлгийн ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ажлын байран дээр болон богино, урт хугацааны цахим сургалтад хамруулж, дадлагажуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулна.

4.1.9 Бугант тосгоны ЭМТ-ийн эмч, эмнэлгийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангана.

#### **4.2. Боловсрол**

4.2.1 Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хүрээнд улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар 2-5 насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсрол олгох үйлчилгээнд бүрэн хамруулах бодлого баримтална.

4.2.2 Ерөө сумын гэрэлт хайлаастын хэсэг, Бугант тосгоны ходоодын хэсэгт хүүхэд харах үйлчилгээг дэмжинэ.

4.2.3 Бугант тосгонд “Хүүхэд залуучуудын хөгжлийн төв”-ийг байгуулах санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулах санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

4.2.4 Сум, тосгоны ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдын мэргэжил сонгоход арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт, лекц зохион байгуулах, мэргэжил сурталчлах, ажлын байртай танилцах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

4.2.5 Сум, тосгонд 4G сүлжээ, Wi-Fi цацах төхөөрөмжийг нэмж суурилуулан интернетээр үйлчлүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

4.2.6 Сум, тосгоны харьяат оюутан, сурагч болон багшийг гадаад, дотоодын нэр хүндтэй их, дээд сургуулиудын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах, орон нутагтаа эргэн ирж ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2.7 Сум, тосгоны алслагдмал газарт амьдардаг сургуулийн насны хүүхдүүдийг нийтийн тээврийн хэрэгслээр тээвэрлэх ажлыг зохион байгуулна.

4.2.8 Ерөө сумын “ЭКО ЛЭНД” хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллана.

#### **4.3 Хөдөлмөр эрхлэлт**

4.3.1 Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлж, орон нутгийн онцлогт тохирох ажлын байр шинээр бий болгох асуудлыг бодлогоор дэмжинэ.

4.3.2 Үр тарианы компаниудад улирлын чанартай ажилладаг орон нутгийн иргэдийг тогтмол ажлын байраар хангах бодлого хэрэгжүүлнэ.

4.3.3 Зорилтот бүлэг болон амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийг орон нутгийн онцлогт тохирсон улирлын болон улирлын бус ажлын байраар хангах бодлого хэрэгжүүлнэ.

4.3.4 Ажилгүй иргэдийг хямд үнэтэй түлшний модоор хангах зорилгоор ойн цэвэрлэгээ хийлгэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.



4.3.5 “Хөдөлмөр зуучлалын төв” байгуулан ажилд зуучлах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн сургалтын үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, “Мэргэжилтэй ажилтан”-г бэлтгэхийг бодлогоор дэмжинэ.

4.3.6 ХАА-н салбарт ажиллах сонирхолтой малчин, тариаланч залуучуудыг дэмжих хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

4.3.7 “Орлоготой оюутан” хөтөлбөрийг орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжтэй хамтран боловсруулж, оюутан залуучуудыг түр ажлын байраар хангах бодлого хэрэгжүүлнэ.

## **5. ЗАСАГЛАЛ**

- Бүтээлч, авлигагүй засаглал
- Чадварлаг төрийн алба
- Иргэдийн оролцоо, хяналт

### **5.1 Бүтээлч, авлигагүй засаглал**

5.1.1 Орон нутагтаа “Бүтээлч, бүтээгч засаглал”-ыг бий болгох бодлого хэрэгжүүлнэ.

5.1.2 Төрийн байгууллагын үйл ажиллагааг хүртээмжтэй, нээлттэй болгож, төрийн албан хаагчдыг хүнд сурталгүй, авлигаас ангид байх нөхцөлийг бүрдүүлж, “Авлигагүй сум” болох бодлого хэрэгжүүлнэ.

5.1.3 Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, ажлын байр бий болгох, зээлийн сонгон шалгаруулалт, санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг нийтэд ил тод, нээлттэй болгоно.

5.1.4 Сум, тосгоны төвөөс алслагдсан малчид, тариаланчдад төр, хувийн хэвшлийн үйлчилгээг тогтмол хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

5.1.5 Иргэдэд газар өмчлүүлэх асуудлыг бүрэн шийдвэрлэх, өмчилсөн газраа барьцаалан санхүүгийн эх үүсвэртэй болох боломжийг нэмэгдүүлнэ.

5.1.6 Малын хулгайн гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг судалж, урьдчилан сэргийлэхийн тулд олон нийтээс мэдээлэл худалдан авах, гэмт хэргийг бууруулахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

5.1.7 Хөрс, ус, агаарыг бохирдуулж байгаа аж ахуй нэгжид хариуцлага тооцож, нөхөн төлбөр төлүүлэх хуулийн хэрэгжилтийг хангуулна.

### **5.2. Чадварлаг төрийн алба**

5.2.1 Төрийн захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчдын чадавхыг сайжруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

5.2.2 Төрийн захиргааны албан хаагчдыг иргэд, олон нийт үнэлдэг системд шилжүүлэх, төрийн албан хаагчдыг хариуцлагажуулах бодлого хэрэгжүүлнэ.

### **5.3. Иргэдийн оролцоо, хяналт**

5.3.1 Хүний эрхийг хамгаалахад төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

5.3.2 Засаглалын бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, шийдвэр боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

5.3.3 Гадаад орнууд болон бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, ОХУ-ын хил залгаа аймаг, мужтай тогтоосон харилцааг өргөжүүлэх бодлого баримтална.





Handwritten signatures and a red stamp with the number 4117143998.

5.3.4 Төрийн албан хаагчдын ажлын туршлагыг харилцан солилцох бүсийн уулзалт, цугларалтыг жил бүр зохион байгуулж, бие биеэсээ суралцах боломжийг бүрдүүлнэ.

5.3.5 Төрийн байгууллагаас гарах шийдвэрт ард иргэд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хүнд суртал, улс төржилтийг арилгах бодлого баримтална.

5.3.6 Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллана.

5.3.7 Иргэд, хууль хяналтын байгууллагын уялдаа холбоог сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинэ түвшинд хүргэж, шуурхай ажиллагааг хангана.

ЕРӨӨ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО

